



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Хөгжимт драмын театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2024/118/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Эвиденсе аудит ХХК-ийн захирал: С.Бадамгарав Утас: 99057121 Цахим хаяг: info@evidenceaudit.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Т.Болортуяа Утас: 99017537 Цахим хаяг: Bolortuya@evidenceaudit.mn Аудиторын туслах: М.Отгонням Утас: 85222519 Цахим хаяг: Otgonnyam@evidenceaudit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН ХӨГЖИМТ ДРАМЫН
ТЕАТРЫН ДАРГА
Т.ЖАВХЛАНЫЯМ ТАНАА

2024. 02.24 № 1/89

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Хөгжимт драмын театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Хөгжимт драмын театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийгмийн хариуцлагын хүрээнд прогресс сургуулийн бага ангийн багш Б.Отгонбаярын Турк улсад эмчлүүлэхэд 120 сая төгрөг шаардлагатай хандивын тоглолтонд бүрэн бүрэлдэхүүнээрээ үнэ төлбөргүй үйлчилсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан

байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛДБААТАР

Нэг . Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мян. төгрөг/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	42,111.55	66,609.03
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	561,457.44	482,788.56
	Нийт хөрөнгийн дүн	603,568.99	549,397.59
	Нийт өр төлбөрийн дүн	-	690.81
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	603,568.99	548,706.78
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	603,568.99	549,397.59
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,215,188.44	1,896,761.55
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,165,070.75	1,951,623.76
	Үйл ажиллагааны үр дүн	50,117.69	(54,862.21)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	50,117.69	(54,862.21)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	603,568.99	603,568.99
	Тайлант оны үр дүн	-	(54,862.21)
	Эцсийн үлдэгдэл	603,568.99	548,706.78
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,119,338.44	1,894,725.87
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,102,836.28	1,819,108.97
	Үйл ажиллагааны ЦМГ	16,502.16	75,616.91
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(7,164.80)	(49,363.93)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	9,337.36	26,252.98
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	9,337.36
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,337.36	35,590.33
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,373,477.70	1,343,089.36
	Урсгал зардал	1,373,477.70	1,343,089.36
	Хөрөнгийн зардал	-	-
	Эргэж төлөгдөх зээл	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,368,943.80	1,368,943.80
	Улсын төсвөөс санхүүжих	1,368,943.80	1,368,943.80
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих /бусад/	-	-
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	-
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	9,337.36
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	35,590.33

Хоёр . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

ДӨРӨВ. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

		Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
№	Төсвийн захирагчийн ангилал	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	1	1			1			
	Нийт	1	1			1			